

## **БНХАУ-ЫН ӨВӨР МОНГОЛЫН ӨӨРТӨӨ ЗАСАХ ОРНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ТОЙМ**

*Ч.Батцэцэг\**

БНХАУ 1978 оноос эдийн засгийн өөрчлөлт шинэчлэл, нээлттэй бодлого явуулж, Хятад онцлогтой социализмыг байгуулах ажлын гараагаа эхэлснээс хойш, Хятадын эдийн засаг амжилттай хөгжиж ард түмний амьжиргааны төвшин харьцангуй дээшилснээр өнөөдөр “нийтээрээ чинээлэг” нийгмийг цогцлон байгуулах үе шатандаа ороод байна.

Хятад улс нийгэм эдийн засгийг 1996-2000 онд хөгжүүлэх IX таван жилийн төлөвлөгөөт зорилтоо амжилттай хэрэгжүүлж дуусгаад, 2000-2005 онд биелүүлэх X таван жилийн төлөвлөгөөний дагуу бүтээн байгуулалтын үйл хэргийг эрчимжүүлж байгаа билээ.

БНХАУ-д өөрчлөлт шинэчлэл, нээлттэй бодлого хэрэгжүүлж эхлэхээс өмнө Өвөр Монголын Өөртөө Засах Орон (ӨМӨЗО) нь эдийн засгийн хөгжлөөр нэлээд хоцрогдсон, бүс нутгийнхаа давуу байдлыг бүрэн дүүрэн ашиглаж чадаагүй орны нэг байв. Харин Өвөр Монголын эдийн засгийн гол үндэс болох мал аж ахуйгаа эдийн засгийн бүтээн байгуулалт, өөрчлөлт шинэчлэлийн явцад хөгжүүлэн малчдын аж амьдралыг дээшлүүлж, мал аж ахуйн үйлдвэрлэлийг сэргээснээр тухайн салбарт амжилт олж, мал сүргийн бүтцийн чанар сайжирч улмаар бэлчээр газар ашиглалт, малын тоо толгой, ноос ноолуур, арьс шир, мах, сүү зэрэг бүтээгдэхүүнээрээ, хөдөө аж ахуйд ажиллах хүн нэг бүрд ногдох үйлдвэрлэлийн нийт хэмжээгээр, нэг хүнд ногдох өндөг, мах, сүүний хэмжээгээр Хятад улсдаа тэргүүлэх болов.<sup>1</sup> Ингэснээр Өвөр Монгол нь дотоодынхоо хэрэгцээг хангаад зогсохгүй Хятадын бусад муж хотуудыг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээр хангадаг болсон байна. Үүний үндсэн дээр мал аж ахуй эрхэлдэг уламжлалт арга хэлбэрийг өөрчилж, орчин үеийн хөгжлийн шинэ загварыг шинжлэх ухааны үндэслэлтэй холбон чанар үр ашгийг дээшлүүлэх зорилт тавьж ирэв.

ӨМӨЗО газар тариалангийн ажлыг нэлээд эрчимжүүлж, 90-ээд оны эхнээс тариачин өрх айлууд бие даан газар авч тариа будаагаа тарих болжээ. Мөн түүнчлэн газар тариалангийн талбайг сайжруулан, усжуулалтын тоног төхөөрөмж суурилуулснаар чухал ач холбогдолтой болсон байна.

БНХАУ 1995 оноос хил хязгаарын захын нутагт эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх төслийг анх удаа хэрэгжүүлж, ялангуяа

\*Ч.Батцэцэг - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

ХКН-ын XV их хурлаас хойш ӨМӨЗО-ы Засгийн газраас үйлдвэр аж ахуйн газрыг дэмжин хөгжүүлэх тухай төрийн бодлого, хууль тогтоолуудыг баталснаар аж үйлдвэр, хувийн үйлдвэр, аж ахуйн газрууд олноороо бий болж, тус ӨЗО-ы эдийн засаг, нийгмийн хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулах болов. Үйлдвэр, аж ахуйн газруудын хэлбэр, бүтэц, зохион байгуулалт улам боловсронгуй болж дотоод, гадаадын зах зээл рүү шилжиж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татаж эхлэв. Үүнтэй уялдуулан ӨМӨЗО-ы Засгийн газраас 1995 онд “Гадаадын хөрөнгө оруулалтыг урамшуулах тухай хөнгөлөлттэй бодлого” зэрэг хууль баталж, цуврал арга хэмжээ авсан нь нээлттэй бодлогыг хөгжүүлэх хэтийн төлвийг тодорхойлсон юм. IX таван жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хөдөө аж ахуй, аж үйлдвэр, худалдаа, соёл боловсрол, эрүүлийг хамгаалах, шинжлэх ухаан-техникийн салбарыг хөгжүүлж, тухайн салбарт мэргэжилтэн сургах, ялангуяа үндэстний цөөнхийн боловсон хүчнийг бэлтгэхэд гол анхаарлаа хандуулж, гадаадын шинжлэх ухаан техникийн ололт амжилтыг чөлөөтэй нэвтрүүлэх зорилт тавьжээ. Нөгөөтэйгүүр үйлдвэр, аж ахуйн газар болон хувиараа эрхлэх аж ахуйн үйл ажиллагааг улсаас хөхүүлэн дэмжиж, Өвөр Монголд том, жижиг, дунд үйлдвэр, аж ахуйн газар хэдэн зуугаараа байгуулагдан үйлдвэрлэл, үйл ажиллагаа явуулж, амьдралын төлөө ард иргэдийн өрсөлдөөн, хамтын ашиг сонирхол идэвхжсэн байна.

90-ээд оны үеийн ӨМӨЗО-ы эдийн засгийн хөгжлийн байдлыг харахад ийнхүү урагшлан хөгжиж байгаа дүр зураг тодорно. Гэвч Өвөр Монголын эрдэмтэн судлаач нар: “Төр засгаас манай бүс нутгийн улс ардын аж ахуйг түргэн хөгжүүлэх бодлого баримталж, өөрчлөлт шинэчлэлийн тогтолцоонд тулгуурлан эрчим хүч, хөрөнгө оруулалтын шаардлага, нөхцөл байдлыг тасралтгүй өргөжүүлж байгаа боловч эдийн засгийн тоон үзүүлэлтийг хуурамчаар өсгөн, эцэст нь сөргөөр нөлөөлж, олон жилийн турш бүтээн байгуулалт болон гадаад, дотоодын зах зээлийн эдийн засгийн өөрчлөлт, шинэчлэлийн нөлөөг сохроор дагасаар Өвөр Монгол хөгжлөөр хоцрогдсон хэвээр үлдлээ”<sup>2</sup> гэж дүгнэжээ. Үүнээс үзэхэд эдийн засгийн өөрчлөлт шинэчлэлийн явцад багагүй бэрхшээл, зөрчилтэй тулгарсаар байгаа ажээ. Тухайлбал: Өвөр Монголын эдийн засгийг хөгжүүлэхэд тулгарч буй гол асуудал нь нэгдүгээрт, ӨМӨЗО хил хязгаарын нутаг болоод зам тээвэр, холбоо мэдээллээр хоцрогдсон өөрөөр хэлбэл хот, хөдөөгийн дэд бүтэц сайн хөгжөөгүй, хоёрдугаарт, байгаль экологийн орчин гэмтэж бохирдсон, байгалийн бэрхшээл (ган, зуд, үер, түймэр, цөлжилт, шороон шуурга г.м) ихтэй, гуравдугаарт, эдийн засгийн бүтэц оновчтой бус, хүнд болон хөнгөн үйлдвэрийн харьцааг арилгах, хүнд үйлдвэрт хөрөнгө оруулалт

их байгаа боловч үр ашиг нь харьцангуй бага гэх мэтийн дутагдал оршиж байсан юм. Нөгөөтэйгүүр байгалийн баялаг элбэг боловч нээн ашиглах чадвар муугаас эдийн засаг, нийгмийн хөгжилд саад болсон хэвээр байлаа.

Ийнхүү Хятад улсад эдийн засгийн суурь, хөгжих нөхцөл байдал, төрийн бодлогын орчны зөрүүгээс зүүн бүс, төвийн болон баруун бүсийн шаталсан байдал үүсчээ. Иймээс Хятад улс өөрчлөлт шинэчлэл, нээлттэй бодлого хэрэгжүүлэхдээ эдийн засгийн стратегийн шат дараалсан чухал арга хэмжээ авч явуулах болов.

90-ээд оны эхээр Дэн Сяопин бүс нутгийн хөгжлийн стратегийн байдлыг тодорхойлохдоо зүүн бүсийн далайн эрэг хавийн нутгуудыг гадаадад нээлттэй болгож, эдийн засаг амжилттай хөгжих үед, өөрөөр хэлбэл, ХХ зууны эцэс гэхэд улс бүхий л хүчээ дайчлан төвийн болон баруун бүсийн хөгжилд анхаарлаа хандуулах, энэ үйл хэрэгт далайн эрэг хавийн нутгийн хүн ам ч туслах хэрэгтэй гэжээ. Хятадын өөрчлөлт шинэчлэл, нээлттэй бодлогын хэрэгжилтийн төвшингөөс хамааран далайн эргийн бүс нутгийн хөгжил, нийгмийн байдал, хүн амын аж амьдрал, соёл, боловсрол, сэтгэлгээ нь баруун хойд бүс нутгийн хүн амаас ихээхэн ялгаатай болжээ. Хятад улс баруун хойд бүс нутгийг хөгжүүлэх эдийн засгийн стратегийн төсөл боловсруулан, эдийн засгийн хөгжилд зохицуулалт хийж, үндэстний цөөнхийн бүс нутгийн хөгжлийн ялгааг аажмаар багасгах талаар тодорхой бодлого баримтлан хэрэгжүүлэх болсон байна.

Хятадын баруун хойд бүс нутаг байгалийн баялаг ихтэй, тухайлбал нүүрс, газрын тос, байгалийн хий, холимог металлын арвин нөөцтэй геостратегийн хувьд маш чухал газар болно.

Хятадын баруун бүсийг эрчимтэй хөгжүүлэх стратегийн төлөвлөгөөнд ӨМӨЗО багтах боллоо. ХКН-ын Төв Хорооны тогтоолд Өвөр Монголын эдийн засаг, нийгмийн хөгжлийг түргэтгэх, зүүн, төв болон баруун бүсийн хоорондын хөгжлийн зөрүүг багасгах, үндэстнүүдийн эв нэгдлийг бататгах, хил хязгаарын тогтвортой байдлыг бэхжүүлэх улмаар Хятадын эдийн засгийн бүтцийг зохицуулах бүс нутгийн хөгжлийг эрчимжүүлэхэд чухал ач холбогдолтойг онцлон заав.

Үүний үндсэн дээр баруун бүс нутгийн хөгжлийг эрчимжүүлэх төлөвлөгөөнд хамрагдсан өөртөө засах орон, муж, хот тус бүр өөрийн онцлогт тохируулан төлөвлөгөө боловсруулжээ.

ӨМӨЗО энэхүү стратегийн хөтөлбөрт хэрхэн хамрагдах, эдийн засгийн аль салбарт бүтээн байгуулалтыг голлож хийх, улсын хөрөнгө оруулалтыг хэрхэн үр өгөөжтэй ашиглах талаар хэлэлцэж, уг төслийн хүрээнд Өвөр Монголын оролцох үндсэн чиглэлийг тогтоосон байна. Үндсэн чиглэлд Өвөр Монголын бодит байдлыг харгалзан, нөөц

бололцоо, давуу талаа чухалчилж, зах зээлийн эдийн засгийн харилцаанд түшиглэн, Хятадын хойд хэсгийн байгаль экологийн хамгаалалтын хамгийн чухал “Гурван бүс” байгуулахаар болжээ. Мөн Өвөр Монголыг Хятадын мал аж ахуй, газар тариалангийн үр өгөөж, байгалийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрийн хөгжлийн чухал бүс; даацын машины тоног төхөөрөмжийн үйлдвэрийн хөгжлийн бүс; газрын эрдэс баялгийн эрэл хайгуул, шинжилгээ-үйлдвэрлэлийг нээх хөгжлийн бүс болгох бүтээн байгуулалтын чухал ажлыг хийж гүйцэтгэхийн зэрэгцээ “Барилгын 10 том бүтээн байгуулалт” хийх болжээ.<sup>3</sup>

Өвөр Монгол нь хөдөө аж ахуй, эрчим хүч, уул уурхайн салбарын үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд харьцангуй давуу талтай. БНХАУ-ын баруун бүс нутгийг эрчимтэй хөгжүүлэх бодлогын үндсэн чиглэлийн нэг нь ӨМӨЗО-ы мал аж ахуйг хөгжүүлэх бодлого юм. ӨМӨЗО-ы бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг бүс нутгийг хөгжүүлэх арга зам, хөгжлийн загвар, уламжлалт хэв маягийг шинэчлэх зорилт дэвшүүлж, мал аж ахуйг орчин үеийн техник технологитой хэрхэн холбох, шинжлэх ухааны үндэслэлтэй үр ашгийг дээшлүүлэх, нүүдлийн мал аж ахуйг аажмаар суурьшуулах, тухайн бүс нутгийн нийгэм-эдийн засгийн байдал, малчин, тариачдын амьжиргааг сайжруулах зэрэг цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлсон шинэ шинэ өөрчлөлтийг амжилттай эхлүүлээд байна.

Өвөр Монголд урд нь малын тоо толгой нэмэгдсэнээр бэлчээрийн даац хэтрэн цөлжилт үүсч хөрс эвдэрч гэмтсэн, байгаль орчин бохирдсон, тухайн салбарт хөрөнгө оруулалт харьцангуй бага гэх мэт нөхцөл байдалд мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх бололцоогүй байв. Иймээс ӨМӨЗО мал аж ахуйгаа эрчимтэй хөгжүүлэхийн тулд нэн тэргүүнд байгаль экологийн нөхцлийг сайжруулахад гол анхаарлаа хандуулаад байна.

Юуны өмнө байгаль экологийг сэргээн засварлах, хамгаалах ажлыг онцолж, газар хагалбарыг зогсоож, мод, өвс тарьж ургуулах, байгаль орчиндоо зохицуулан хүн ардыг нүүлгэн шилжүүлэх, Хятадын хойд зүгийн газар нутгийн хамгаалалтын гурван бүсийг ойжуулах, цөлжилтөөс хамгаалах, элсний нүүдэл, шороон шуургыг зогсоох зэрэг арга хэмжээ авч, судалгаа, туршилтын ажлыг хийж, олон төсөл хэрэгжүүлж байна. Дашрамд манай улсын хувьд ч ялгаагүй байгаль экологийн асуудалд Өвөр Монголтой адил бэрхшээл тулгарч байгаа тул энэ салбарт харилцан туршлага солилцох, гадаадын хөрөнгө оруулалтыг татаж оролцуулах, зөвхөн төсөл хэрэгжүүлэх нэрээр хурал, семинар хийх бус, бодитой үйл ажиллагаа, хамтарч ажиллах явдлыг эрчимжүүлэх шаардлагатай байгаа юм.

Хятадын баруун бүс нутгийн авто замын сүлжээ нь тус бүс нутгийн зам харилцаанд чухал үүрэг гүйцэтгэдэг. Иймээс өнгөрсөн дөрвөн жилд ӨМӨЗО “хөндлөнгийн гурав, гулд ес, арван хоёр гарц” гэсэн авто замын бүтээн байгуулалтын ажлыг хийх зорилт дэвшүүлж, нийт 40,8 тэрбум юаний хөрөнгө оруулалт хийж, зүүн, баруун чиглэлийн муж хоорондын авто замыг бүтээн байгуулах томоохон чухал төслүүдийг хэрэгжүүлж, шинээр 11,2 мянган км, нийт 74 мянган км авто замтай, нийт 7475 км төмөр замтай болоод байна.<sup>4</sup>

ӨМӨЗО-ы аж үйлдвэрийн салбар харьцангуй түргэн хөгжиж, аж үйлдвэрийн нийт нэмүү өртөг 57,1 тэрбум юанд хүрч, жилд дунджаар 11,3 хувиар өсчээ. Аж үйлдвэрийн гол бүтээгдэхүүн тогтвортой өсч, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах, эрчим хүч болон түүхий эдийн үйлдвэр эрчимтэй хөгжиж, бүх Хятадын хэмжээнд 7 төрлийн барааны “нэрт шошго” зах зээлийг эзлэх болов.<sup>5</sup>

ӨМӨЗО-д Х таван жилийн төлөвлөгөөт ажлын хугацаанд хувийн хэвшлийн салбарын үйл ажиллагаа хэлбэрэлтгүй нэмэгдэж, урьд өмнө худалдаа, хоол хүнс, үйлчилгээний аж ахуй голлож байсан бол өнөөдөр хөдөө аж ахуй, авто зам, байгаль экологийн бүтээн байгуулалтын салбарт шилжих болжээ. Тухайлбал: хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах, эрчим хүч, барилга, зам тээвэр, худалдаа зэрэг 8 том ажилд хувийн хэвшлийнхний эзлэх хувийн жин тасралтгүй өргөжиж байна. Одоогийн байдлаар тус ӨЗО-ы 27 хувиараа эрхлэх аж ахуйн нэгж (ХЭААН) импорт, экспортын эрх гардаж, 55 ХЭААН бүтээгдэхүүнээ экспортолж байна. Мөн түүнчлэн зарим аж ахуйн нэгж хилийн чанадад аж ахуй эрхэлж улмаар олон улсын зах зээлд гарах болов.<sup>6</sup>

Хувийн хэвшлийн салбар ийнхүү түргэн хөгжиж эдийн засгийн томоохон корпорациудыг бий болгосон байна. Үүнд: “Мэн ню” корпораци, “Лу ван”, “Дун да” гэх мэт ноолуурын үйлдвэр, “Пань гу”, “Най лунь”, “Цянь кунь” алт мөнгөний хувьцаат компани болон “Хэ фа” газрын шорооны хувьцаат компани зэрэг аж ахуйн нэгж нь бусад аж ахуйн нэгжээс тэргүүлж Өвөр Монголын эдийн засгийн өсөлтийн үндсэн хэсэг болж чаджээ. Гэтэл манай улсын хувийн хэвшилд Өвөр Монголын хувь нийлүүлэгчдийн хамтарч ажиллаж буй салбар нь үйлчилгээ, худалдаа, хоол хүнс, малын түүхий эд бэлтгэх зэргээс хэтрэхгүй байна. Өвөр Монголын томоохон компаниуд манай улсын уул уурхайн салбарт хөрөнгө оруулж, хамтарч ажиллах хүсэлтэй байдаг боловч манай талаас нэлээдгүй бэрхшээл тулгардаг талаар тэдний судлаач эрдэмтэд өөрийн санал, үзэл бодлоо бичиж ирэв.

2000-2004 онд ӨМӨЗО-ы нийгмийн үндсэн хөрөнгө дэх хөрөнгө оруулалт өсч, эдийн засгийн үр өгөөж дээшилснээр тус бүс нутгийн бие

даах хүчин чадал ихээхэн нэмэгдсэн байна. Энэ хугацаанд Өвөр Монголын ДНБ жилд дунджаар 11,9 хувиар өссөн нь бүх Хятадын дундаж төвшин болон баруун бүс нутгийн дундаж төвшингөөс харьцангуй өндөр байна. Нөгөөтэйгүүр тус ӨЗО-ы гадаад худалдааны импорт, экспортын нийт эргэлт 10,7 тэрбум юаньд хүрч, жилд дунджаар 18 хувиар өссөн байна.<sup>7</sup>

ӨМӨЗО-ы дарга Оюунчимэг 2003 оны 1-р сарын 11-нд ӨЗО-ы АТИХ-ын Х дахь удаагийн анхдугаар хуралдаан дээр тавьсан тайлан илтгэлдээ дараагийн таван жилд хийх ажлын талаар арван зорилт дэвшүүлсэн байна. Үүнд:

Нэгдүгээрт. Хөдөө аж ахуй, мал аж ахуй эрхэлдэг орон нутгийн эдийн засгийг түргэн хөгжүүлж, малчин, тариачдын орлогыг нэмэгдүүлэхэд гол чухал үүрэг гүйцэтгэх аж.

Хоёрдугаарт. ӨЗО-ы онцлогтой шинэ хэлбэрийн аж үйлдвэрийг хөгжүүлэхдээ орчин үеийн мэдээллийн эринтэй нийцүүлсэн, шинжлэх ухаан, технологи, эдийн засгийн үр ашигтай, байгалийн бохирдолгүй, ажиллах хүчний нөөцийн давуу талыг дээдэлсэн аж үйлдвэржүүлэлтийг бий болгох юм байна.

Гуравдугаарт. Үйлчилгээний салбарыг ихээхэн хөгжүүлж, суурьшуулах, хотжих явцыг түргэтгэх;

Дөрөвдүгээрт. Байгаль экологийн бүтээн байгуулалт нь баруун бүс нутгийн хөгжлийн гол үндэс учраас байгаль экологи, дэд бүтцийн бүтээн байгуулалтыг цаашид үргэлжлүүлэн түргэтгэх ажээ.

Тавдугаарт. Хувийн хэвшлийн салбарыг хөгжүүлэхдээ орон зайг өргөтгөх, аливаа оновчгүй хязгаарлалтыг хүчингүй болгон цуцалж, зах зээлд чөлөөтэй гарахыг зөвшөөрөх, хөрөнгө хуримтлуулах, газар эдэлбэр ашиглах, мэргэжилтэн урьж ажиллуулах зэрэгт хориг саад тавихгүй байх зэргээр дэмжих тухай заасан байна.

Зургадугаарт. Өөрчлөн байгуулалтын явцыг түргэтгэн эдийн засаг нийгмийн хөгжилд шинэ хөдөлгөх хүчийг бий болгоно. Үүнд: орчин үеийн аж ахуйн нэгжийн дүрэм, журмыг шаардлагын дагуу засч залруулан, хуулийн этгээдийн удирдах бүтцийг төгөлдөржүүлэх юм байна.

Долдугаарт. Санхүү, банк, татварын ажлыг сайжруулан, макро зохицуулалт хийж, санхүүгийн тогтолцоог өөрчилж, үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, санхүүгийн эх үүсвэрийг бий болгох ажлыг сайтар хэрэгжүүлэх ажээ.

Наймдугаарт. Ард түмний аж амьдралыг сайжруулах ажилд гол анхаарлаа хандуулж, хот хөдөөгийн ард иргэдийн амьжиргааны төвшинг дээшлүүлнэ. Ялангуяа тус ӨЗО-ы хот хөдөөгийн оршин суугчдын орлогын өсөлт удаашралтай байгааг идэвхжүүлэн шийдвэрлэх асуудал чухал байгааг онцлон тэмдэглэжээ.

Есдүгээрт. Шинжлэх ухаан техникийн тогтолцоог өөрчилж, академи, хүрээлэн, эрдэм шинжилгээний байгууллагуудыг зах зээлд шилжих явц, өөрчлөлтийг түргэтгэх замаар шинжлэх ухаан, боловсролыг дээдлэн ӨЗО-ы тогтвортой хөгжлийн стратегийг хөгжүүлэх болно.

Аравдугаарт. Үзэл суртлын хүрээнд марксизм-ленинизм- Мао Цзэдуны үзэл санаа болон Дэн Сяопиний онолыг удирдлага болгож, суртал ухуулгын ажлыг гүнзгийрүүлэх талаар бичсэн байна.

БНХАУ-ын Баруун бүс нутгийн хөгжлийг эрчимжүүлэх төслийн хүрээнд ӨМӨЗО төлөвлөгөөндөө тусгасан ажлуудыг хэдийд ямар хугацаанд хэрхэн гүйцэтгэх талаар урьдчилсан тооцоо гаргасан байна. Байгаль экологийн бүтээн байгуулалтын хувьд 2005 онд анхны үр ашигаа олох, 2015 онд нэлээд үр дүнд хүрэх, XXI зууны дунд үе гэхэд бүрэн хэрэгжсэн байх ажээ. 2005 онд Өвөр Монголын Өөртөө Засах Орны ард түмний амьдрал нэлээд чинээлэг болж, 2015 онд нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээгээр бүх Хятадын дундаж төвшинд хүрч, XXI зууны дунд үед Өвөр Монголыг “Дараагийн зууны Хятадын эдийн засгийн өсөлтийн чухал тулах цэг” болгохоор тооцоолсон байна. Ийнхүү БНХАУ-ын баруун бүс нутгийн хөгжлийг эрчимжүүлснээр зүүн бүсийн харьцангуй хөгжилтэй бусад нутгийн хөгжлийн зөрүүг арилгаж, 2020 он гэхэд Хятад улсын хэмжээнд ядуурлыг бүр мөсөн устгах зорилт тавьж байгаа юм байна. Үүнд ӨМӨЗО-ы оролцоо маш чухал үүрэг гүйцэтгэх болно.

### ИШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. “Олон улс судлал” УБ., 2000, №1. Насан. Өвөр Монголын мал аж ахуй ба нутаг бэлчээрийг ашиглах тухай.
2. Гуан юй дан цянь нэймэнгу цзи чжи цю цзин гэ чжэдянь вэньти. (ӨМӨЗО-ы эдийн засгийн өнөөгийн тулгамдсан хэдэн асуудлын тухай) ӨМНШУ сэтгүүл. 1999 №9. Vol. 117. №5 т.86
3. “Олон улс судлал” сэтгүүл. УБ., 2001 №1
4. “Солонго” сэтгүүл. Хөххот. 2004.5 №119 т.20
5. “Солонго” сэтгүүл. Хөххот. 2003.3 №105 т.7
6. “Солонго” сэтгүүл. Хөххот. 2004.4 №118 т.18
7. “Солонго” сэтгүүл. Хөххот. 2004.5 №119 т.20